

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: **2019-04-16**

Тендер шалгаруулалтын нэр: БНСУ-ын Гуяан хотын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байгаа “Аз жаргалын төгөл” 100 га ойн зурвасын усалгааг цэвэр усны төвлөрсөн системд холбох ажил

Тендер шалгаруулалтын дугаар: **ДУГАОНӨГ/201912001**

**Дундговь аймгийн Засаг даргын тамгын газар, Орон нутгийн өмчийн газар нь** эрх бүхий тендерт оролцогчдоос БНСУ-ын Гуяан хотын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байгаа “Аз жаргалын төгөл” 100 га ойн зурвасын усалгааг цэвэр усны төвлөрсөн системд холбох ажилыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу. Мөн цахим тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан "Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам"-ын дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50.000 (тавин мянган) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: 2017, 2018 оны дундаж нь 70 сая төгрөгөөс **багагүй байх**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Төсөвт өртөгийн 30 хувиас багагүй байх

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил **2017, 2018**

Ижил төстэй ажлыг гүйцэтгэсэн туршлагын талаарх ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил 2017,2018

**Тусгай зөвшөөрөл шаардлагатай** : Барилга угсралтын тусгай зөвшөөрөлтэй байх бөгөөд 2.2.4 буюу Дулааны болон усан хангамжийн гол /магистраль/ шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт гэсэн заалттай байна

Цахим тендерт оролцогч нь 1,371,118 **төгрөгийн дүнтэй** тендерийн баталгаа гаргана.

Тендерийг **2019 оны 05-р сарын 17-** ны өдрийн **10 цаг 30** минутаас өмнө [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлнэ.

Нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 05-р сарын 17** -ний өдрийн, **11 цаг 00** минутад нээнэ.

**Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.**

**Дотоодын давуу эрхийн зөрүү тооцно.**

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Дундговь аймаг, Орон нутгийн өмчийн газар**  
**Утас: 70593399, 90117199**

